

БИБЛИЙН ҮНДЭС курсын гарын авлага.

Хуучин Гэрээний Хаанчлал, Гэрээ ба Канон Шинэ Гэрээн дэх Хаанчлал ба Гэрээ

ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү хичээл нь Библийн үндсэн хоёр сэдэв болох Бурханы хаанчлал ба тэнгэрлэг гэрээнүүдийн биеллийг Библийн каноны үүслийн талаарх нэг хичээлийн хамт судалж, эдгээрийн талаарх товч ойлголтуудыг өгөх болно. Бид Хуучин ба Шинэ Гэрээ нь түүх, сургаал, эш үзүүлэгийн мэдээний санамсаргүй цуглуулга биш, харин гэрээнүүдээр дамжуулан засаглах Бурханы хаанчлалын тухай нэгдмэл агуулгатай гэдгийг харна. Уг хичээл нь Гурав дахь Мянгын үйлчлэлээс бэлтгэн гаргасан, Др. Ричард Пратт, Жр болон Др. Симон Вибэрт нарын хөтөлж заасан [Хуучин Гэрээний Хаанчлал, Гэрээ ба Канон](#) мөн [Шинэ Гэрээн дэх Хаанчлал ба Гэрээ](#) гэсэн хоёр цуврал видео хичээлээс бүрддэг.

ЭНЭ КУРСЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД БАС ХИЧЭЭЛҮҮДИЙН ЖАГСААЛТ

Зорилго

Уг хичээлээр бид дараах зорилгонд хүрэх болно:

1. Бид таныг хичээлийн бүхий л хэсгүүдээр дамжуулан доорх үр дүнгүүдэд хүрнэ гэж найдаж байна:
 - Хуучин ба Шинэ Гэрээн дэх Бурханы Хаанчлалын тухай сэдвийн нэгдмэл байдлыг олж харах
 - Хуучин ба Шинэ Гэрээний түүхэн дэх Бурханы Гэрээнүүдийн зорилгыг ойлгох
 - Хуучин ба Шинэ Гэрээний Сургаал номлолыг нь өнөө цагт бид амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх ёстойг олж мэдэх
2. Бид таныг Хуучин ба Шинэ Гэрээг судлах илүү их хүсэл сонирхолтой болно гэж найдаж байна.
3. Та энэ хичээлийг үзсэнээр амьдралдаа өөрчлөлт хийнэ гэдэгт итгэлтэй байна. Энэ нь танд Библийн бүхий л хэсгийг тайлбарлаж, хэрэгжүүлэхэд туслах болно.

Зорилтууд

Та доорх зорилтуудыг биелүүлснээр зорилгууддаа хүрэх болно:

1. Асуулт ба шалгалтуудад сайн үнэлгээ авснаар дараах зүйлсийг тодорхойлж чадна:
 - Хуучин болон Шинэ Гэрээнд бичигдсэн Бурханы хаанчлалын тухай түлхүүр ойлголтууд

- Хуучин Гэрээний гол гэрээнүүд болон тэдгээрийн Шинэ Гэрээний харилцан хамаарал
 - Өнөө цагт буй Хуучин ба Шинэ Гэрээг ашиглах хүчин төгөлдөр зарчмууд
2. Хичээлийн хөтөч болон бусад даалгавруудыг гүйцэтгэхдээ Хуучин Гэрээний талаарх өөрийн бодол, хандлагаа илэрхийлэх, мөн багц хичээлээс сурсан зүйлсээ өөрийн амьдралд хэрхэн хэрэгжүүлснээ хуваалцах, ялангуяа Хуучин Гэрээний хэсгүүдийг тайлбарлан, хэрэгжүүлэхдээ Хуучин Гэрээний нэгдмэл байдал, гэрээнүүдийн түүх болон Бурханы хаанчлалын тухай сэдвийг харгалзан үзэх.
 3. Утга агуулгыг бүрэн ойлгож, амьдрал болон үйлчлэлдээ хэрэгжүүлэхийн тулд долоо хоног бүрийн хэлэлцүүлэгт оролцож, Гурав дахь Мянганы видео хичээлүүдээс сурсан зүйлсээ дүгнэн ярилцаж байх.

Библийн Суурь Курсын хичээлүүдийн жагсаалт

1. Хуучин Гэрээг яагаад судлах ёстой вэ?
2. Хуучин Гэрээн дэх Бурханы хаанчлал
3. Тэнгэрлэг гэрээнүүд
4. Хуучин Гэрээний канон
5. Шинэ Гэрээг яагаад судлах ёстой вэ?
6. Шинэ Гэрээн дэх Бурханы хаанчлал
7. Шинэ Гэрээ

КУРСЫН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮДИЙН ТАЙЛБАР

Тэмдэгтүүд

1. Та долоо хоног бүр бүлгийн хэлэлцүүлгийн цагийн тодорхой хэсгийг ***Тэмдэгтийн Заавар*** дээр ажиллахад зориулах хэрэгтэй. Энэхүү хоёр нүүр гарын авлага таны Сургагчид багшид заар өгөх бөгөөд үйлчлэлийн чухал чадвараа хөгжүүлэхийг зорьж буй танд туслах болно.
2. Сургалтын эхний долоо хоногуудад хэлэлцүүлгийн цагаар Тэмдэгтийн Зааварт буй *Хэлэлцэх Сэдвүүдийн* дагуу явах болно.
3. Багийн хэлэлцүүлгээр дамжуулан бат бөх сууриа тавьсан гэж үзвэл үлдсэн долоо хоногуудад нь *Хэрэгжүүлэх Алхмуудын* тэмдэгт дээр ажиллаарай.
4. Хэрэв сургагч багш тань таныг Тэмдэгтийн зааврын дагуу хэрэгжүүлэх алхмуудаа бүрэн гүйцэтгэсэн гэж тооцвол тэмдэгтээр шагнах болно. Таны авсан тэмдэгт тань цахим ангийн тань суралцагчийн "үүргэвч" хэсэгт харагдах болно.

Медиа Хичээлүүд

1. Хичээлүүдийг судлахдаа **видео хичээл** үзэх ба хүсвэл **аудио хичээл** сонсож, **текст хувилбарыг** уншиж болно.

2. Хичээл бүрийн **Суралцах Хөтчийг** гүйцэт ажиллаарай. Суралцах хөтөч нь таныг цахим сорил (Дүгнэлт асуултууд) өгөхөд бэлдэхээс гадна хичээлээс сурсан зүйлсээ амьдралдаа хэрэгжүүлэхэд тань тусална.
3. Хичээл бүрийн цахим сорилыг (**Дүгнэлт асуултууд**) бөглөөрэй. Та хэдэн ч удаа сорил өгч болно. Гэхдээ дахин өгөхийн тулд нэг цаг хүлээх хэрэгтэй. Таны авсан хамгийн өндөр оноо таны албан ёсны дүнд тооцогдоно. Хичээлийн агуулгыг үнэн зөв ойлгосон эсэхээ баталгаажуулахын тулд долоо хоног бүрийн хэлэлцүүлэгт оролцохын өмнө хамгийн багадаа 80% дүн авахыг бид танд зөвлөж байна.
4. Та багаараа болон сургагч багштайгаа долоо хоног бүрийн хэлэлцүүлэгт оролцохдоо тухайн хичээлийн **Хэлэлцүүлгийн Хөтчийг** ашиглаарай. Эдгээр хэлэлцүүлгүүд нь хичээлийн агуулгыг бүрэн ойлгож, амьдрал болон үйлчлэлдээ зөв зүйтэй хэрэгжүүлэх чадвартай болоход тань амин чухал юм. Видео хичээлийнхээ талаар тус бүр доод тал нь нэг цаг хэлэлцэж, ярилцахыг бид танд зөвлөж байна.

Эцсийн шалгалт

Библийн Үндэс хичээлийн Эцсийн шалгалтыг өгөөрэй. Та шалгалтыг хэдэн ч удаа өгч болно. Гэхдээ дараагийн удаа дахин өгөхийн тулд нэг цаг хүлээх хэрэгтэй. Таны авсан хамгийн өндөр оноо таны албан ёсны дүнд тооцогдоно. Энэ курсыг бүрэн дүүргэхийн тулд та хамгийн багадаа 80% дүн авсан байх шаардлагатай.

ҮНЭЛГЭЭ

Эцсийн үнэлгээг дараах байдлаар тооцно:

1. Хичээлийн сорил тус бүр 30 оноо.
2. Хичээлийн эцсийн шалгалт 100 оноо.
3. Сайнмэдээний Тэмдэгт нь дүнд нөлөөлөхгүй боловч та хичээлийг бүрэн дуусгахын тулд заавал цуглуулсан байх ёстой.

Хичээлийн нийт оноо 80%-иас дээш бол тэнцсэн гэж үзнэ.

Энэхүү хичээлийг хамтран бүтээгчдийн нэрс (эрхэлдэг ажил болон байгууллага нь бичлэг хийгдсэн цаг үеийнх болно)

Др. Дэвид Р. Бауэр бол Библийн Тайлалын Сургуулийн декан ба Асбури Теологийн сургуулийн Индуктив Библи судлалын Ралф Валдо Бийсон Профессор.

Др. Рик Боед бол Весли Библийн сургуулийн Библийн Тайлалын Профессор.

Др. Константин Р. Кэмпбел бол Тринити Эвангеликал Дивайнити Сургуулийн Шинэ Гэрээний дэд профессор.

Др. Д.А. Карсон бол Тринити Эвангеликал Дивайнити Сургуулийн Шинэ Гэрээний судалгааны профессор ба Госпел Коалишн байгууллагын хамтран үүсгэн байгуулагч.

Др. Роберт Б.Кисхолм, Жр. бол Даллас Теологийн Сургуулийн Хуучин Гэрээний профессор ба тэнхимийн эрхлэгч.

Др. Ашиш Криспал бол Оверсийс Зөвлөлийн Ази тивийг хариуцсан бүсийн захирал.

Др. Давид Корри бол Мексикийн Мерида дахь Сан Пабло Теологийн Сургуулийн дэд профессор. Прогресо дахь Пресбитериан Иглесиа Есүс чуулганы пастороор үйлчилдэг.

Др. Брандон Д. Крове бол Вестминстр Теологийн Сургуулийн Шинэ Гэрээний дэд профессор.

Ноён. Шериф Атеф Фахим нь Египет дэх Александриа Теологийн сургуульд багшилдаг.

Рев. Майкл Ж. Глодо бол Флорида муж, Орландо хот дахь Реформед Теологийн Сургуулийн Библи судлалын дэд профессор.

Др. Дуглас Гропп нь Хуучин Гэрээний профессор, Редиймэр Сургуулийн хичээлийн дэд эрхлэгч асан

Др. Жеймс М. Хамилтон бол Өмнөд Баптист Теологийн Сургуулийн Библийн теологийн дэд профессор ба Кенвүүд Баптист чуулганы номлогч пастор.

Др. Жоел К. Хантэр бол Флорида, Лонвүүд дэх Нортланд чуулганын Ахлах пастор.

Рев. Клет Хакс бол Алабама муж, Бирмингхам дахь Аположетикс Ресурс Төвийн Захирал ба Шүтээн Мөргөлийн эсрэг Итгэлээ Өмгөөлөгч.

Др. Таддай Ж. Жеймс, Жр бол Бирмингхамын Теологийн Сургуулийн сургалт хариуцсан дэд ерөнхийлөгч.

Др. Марк А. Женнингс бол Гордон Конвэл Теологийн Сургуулийн Шинэ Гэрээний гэрээт Профессор.

Ноён. Брадли Т. Жонсон бол Асбури Теологийн Сургуулийн гэрээт профессор ба Кентаки дахь Николашвилын Вэсли Чапэл Юнайтэд Методист Чуулганы Пастор

Др. Деннис И. Жонсон бол Калифорниагийн Вестминстр Сургуулийн Практик Теологийн Гавьяат Профессор

Др. Жим Жордан бол Трэйнин Лийдэрс Интернэшнлийн олон улсын сургагч багш.

Др. Эдвард М. Кийзариан бол Гордон Конвэл Теологийн Сургуулийн Грек хэлний туслах Профессор ба Грек Хэлний Хөтөлбөрийн Удирдагч

Др. Грейг С. Кийнэ бол Асбури Теологийн Сургуулийн Ф.М ба Ада Томпсоны Библи Судлалын Захирал.

Др. Даниэл Ким бол Ковенант Теологийн Сургуулийн Хуучин Гэрээний багш.

Рев. Кевин Лабби бол Флорида мужийн Винтер Спрингс дэх Виллоу Крик чуулганы Ахлах Пастор.

Др. Дан Лагих бол Флорида мужийн Орланда дахь Нортланд чуулганы пасторын багт үйлчилдэг.

Др. Ричард Линтс бол Гордон-Конвел Теологийн Сургуулийн Сургалт Хариуцсан Дэд Ерөнхийлөгч ба Теологийн Профессор.

Др. Роберт МакИвен бол Сингапур улсын Зүүн Азийн Теологийн Сургуулийн Хятадын Теологийн Тэнхимийн захирал ба Библи Судлалын Багш.

Др. Шон МкДонау бол Гордон-Конвел Теологийн Сургуулийн Шинэ Гэрээний Профессор.

Рев. Тимот Маунтфорт бол Баруун Хятадын Ковенант Теологийн Сургуулийн Хичээлийн Эрхлэгч.

Др. Маттею Ньюкирк бол Япон улсын Окозаки дахь Христ Библийн Сургуулийн Ерөнхийлөгч, Хуучин Гэрээний Профессор.

Др. Жеффрэй Ж. Найхауис бол Гордон-Конвел Теологийн Сургуулийн Хуучин Гэрээний Профессор.

Др. Жэйсон Оакес бол Талбот Теологийн Сургуулийн Христэч Сэтгэлгээний Туслах Профессор.

Др. Луйс Ортеза бол Бирминхам Теологийн Сургуулийн Зөвлөх Профессор.

Др. Грант Р. Осборн (1942-2018) бол Эвангеликал Дивинити Сургуулийн Шинэ Гэрээний Профессор агсан.

Др. Жон Освалт бол Асбури Теологийн Сургуулийн Хуучин Гэрээний Хүндэт Зочин Профессор.

Др. Алвин Падилла бол Гордон Конвелл Теологийн Сургуулийн Профессор, Латин Америкийн Үйлчлэлийн Эрхлэгч.

Др. Ионатан Т. Пеннигтон бол Өмнөд Баптист Теологийн Сургуулийн Шинэ Гэрээний Орчуулгын Дэд профессор ба Докторын судалгааны захирал.

Др. Грэг Пэрри бол Миссори дахь Ст. Луйс хотын Ковенант Теологийн Сургуулийн Шинэ Гэрээний Дэд Профессор, Хотын Үйлчлэлийн Санаачлагын захирал

Иоханес Праптоварсо нь Философын Ухааны Доктор, Бату дахь Теологийн Сургуульд үйлчилдэг.

Др. Клей Куартемэн бол 2019 онд тэтгэвэрт гарах хүртлээ Украин улсын Эвангеликал Реформед Сургуулийн Ерөнхийлөгч байсан.

Др. Скотт Рэд бол Вашингтон Д.С дэх Реформед Теологийн Сургуулийн Захиргааны Ахлах Ажилтан, Хуучин Гэрээний Дэд Профессор.

Рэв. Рик Роудхивэ бол Калифорниагийн Лагуна Хиллс дэх Христийн Коммунити Чуулганы Ахлах Пастор.

Др. Майк Рос нь Хойд Каролинагийн Шарлотте дахь Реформед Теологийн Сургуульд Практик Теологи заадаг бөгөөд мөн Хойд Каролинагийн Маттью дахь Христ Ковенант Чуулганы ахлах пастор байсан.

Др. Брайн Д. Рассел бол Флоридагийн Орландо дахь Асбури Теологийн Сургуулийн Библи Судлалын Профессор, Урбан Үйлчлэлийн Сургуулийн Эрхлэгч.

Др. Филип Райкен бол Вийтон Коллежийн Ерөнхийлөгч.

Др. Экхард Ж. Шнабел бол Гордон-Конвел Теологийн Сургуулийн Шинэ Гэрээний Мари Ф. Рокфеллерын Нэрэмжит Профессор.

Др. Глен Г.Скоржи Сан Диего дахь Бетэл Сургуулийн Теологийн Профессор.

Др. Даниел Шиманго бол Кэйп Таун дах Өмнөд Африкийн Библийн Хүрээлэнгийн Захирал.

Др. Вүяани Синдо бол Өмнөд Африкийн Жорж Вайтфилд Коллежийн багш.

Др. Даниел Стеффен бол Гуатемал хотын Сентроамерикано Теологийн Сургуулийн Зочин Профессор.

Др. Марк Л. Страусс бол Сан Диего дахь Бетэл Сургуулийн Шинэ Гэрээний Профессор.

Др. Дерек Томас бол Жорж муж. Атланта хотын Реформед Теологийн Сургуулийн Системт ба Түүхэн Теологийн Профессор.

Рев. Др. Симон Вебэрт бол Их Британий Вимблдон Паркын Гэгээн Лукийн Сүмийн санваартан асан, мөн Оксфордын Вайклиф Танхимын Дэд Захирал, Номлохуйн Сургуулийн Захирал.

Др. Петр Волкэр нь Үйлчлэлийн Тринити Сургуулийн Библи Судлалын Профессороор мөн Оксфордын Уайклиф Танхимын туслах Дэд Захирлаар үйлчилж байсан. Библи судлалын Иерусалим Төвийн захиралаар ажиллаж байна.

Др. Стефен Ж. Вэллум бол Өмнөд Баптист Теологийн Сургуулийн Христитгэлийн Теологийн Профессор.

Др. Стефен И. Витмэр бол Гордон-Конвел Теологийн Сургуулийн Шинэ Гэрээний Гэрээт Профессор.

Др. Ионатан Д. Вортинтон бол Лийдэрс Интернэшнл Трэйнингийн Хөтөлбөр Хөгжүүлэлтийн Удирдагч.